



ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАН

СУРГУУЛИЙН НЭР: **Отгонтэнгэр Их Сургууль**

ХӨТӨЛБӨРИЙН НЭР: **Бизнесийн удирдлага**

ХӨТӨЛБӨРИЙН ИНДЕКС: **D041301**

Шинжээчийн баг:

Ахлагч: Г.Баттүвшин /Ph.D/

Гишүүд: Л.Тогтохбуян /Ph.D/

Э.Эрдэнэчимэг /Ph.D/

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Ү. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

- I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Отгонтэнгэр Их Сургууль Otgontenger University	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Бизнесийн удирдлага (Санхүүгийн удирдлага) Business administration (Financial management)	
Индекс	D041301	
Шинжээчид	1. Г.Баттүвшин /ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвгний сургуулийн захирал/ 2. Л.Тогтохбуян /ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн ахлах багш/ 3. Э.Эрдэнэчимэг /ХУИС-ийн Бизнесийн сургуулийн багш/	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	П.Оргилмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2019.12.20	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2019.12.20	Шинжээчид өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгөх
	2019.12.23	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.12.24-25	Сургууль дээр шинжээчид очиж ажиллана.
	2020.01.10	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020.01.15	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2019.01.20	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.01.20	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Отгонтэнгэр их сургууль 1991 онд байгуулагдсан Монгол Улс дахь хувийн хэвшлийн анхны их сургуулийн нэг бөгөөд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш өдгөө 28 дахь жилдээ дээд боловсролын сургалтын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн дагуу явуулж байна. Тус сургууль 1999 онд Монгол Улсад магадлан итгэмжлэгдсэн анхны дээд сургууль болж улмаар “Их сургууль”-ийн статустай болсон төдийгүй 2004 онд 2 дахь удаагаа, 2018 онд 3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн байна.

2005-2006 оны хичээлийн жилд бүтцийн өөрчлөлт хийж Хууль зүй, Эдийн засаг бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн гэсэн бүтцийн гурван сургуультай болж сургалтын үйл ажиллагаа өргөжүүлсэн ба 2012-2013 оны хичээлийн жилд Дээд боловсролын байгууллагын аттестатчилалд хамрагдаж “Аттестатчилалд тэнцсэн” гэрчилгээ авсан. Мөн 2017 онд АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэх зөвлөл /ACBSP/-ээр магадлан итгэмжлэгдсэн.

Энэ хугацаанд байгууллагын төлөв байдлыг тодорхойлох, сургуулийн үйл ажиллагааны ерөнхий бодлого, төлөвлөлтийг хийж ажиллажээ. Мөн байгууллагын тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Хөгжлийнхөө түүхэн он жилүүдэд хуримтлуулсан туршлага, ололт амжилтаа бататгаж улмаар үндэсний болон дэлхийн боловсролын хөгжлийн цаашдын чиг хандлагад нийцүүлэн хөгжих шинэчлэлийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагад нийцүүлж Захирлын 2013 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 21 тоот тушаал, Удирдах зөвлөлийн 2013 оны 04 сарын 04 өдрийн 21 тоот тогтоолоор “Отгонтэнгэр их сургуулийн 2013-2022 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөөгөө баталжээ.

2014 онд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр Бизнесийн удирдлага (Санхүүгийн менежмент), Нягтлан бодох бүртгэл, Эрх зүй (аж ахуйн эрх зүй, олон улсын эрх зүй), Багш гадаад хэлний боловсрол (англи хэл), Гадаад хэлний орчуулга (хятад хэл) гэсэн 7 хөтөлбөр үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн байна. Тус сургуулийн хамт олон дээд боловсролын хүрээнд төрөөс хэрэгжүүлж байгаа шинэчлэл болон төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж ирсэн нь харагдаж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-д тавигдах нийтлэг шаардлага”-ыг үндэслэн сургуулийн хэмжээнд хөтөлбөрийн шинэчлэл хийх ажлыг төлөвлөж Захирлын 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 67 тоот тушаалаар Отгонтэнгэр их сургуулийн хөтөлбөрийн хорооны түр журам, ерөнхий болон дэд хорооны бүрэлдэхүүнийг баталж хөтөлбөрийн хорооны хүрээнд тухайн хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, шинэчлэх ажлуудыг үе шаттай хэрэгжүүлж иржээ.

2015-2016 оны хичээлийн жилд БСШУЯ-аас хэрэгжүүлсэн “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-ийн зөвлөх үйлчилгээний хүрээнд хийхээр

төлөвлөсөн шинэ загвар, стратегиудыг туршиж хэрэгжүүлэх түшиц сургуулиар сонгогдон /БСШУ-ны сайдын А/147 тоот тушаалаар батлагдсан/ ажиллаж байгууллагын бодлого, төлөвлөлт, гүйцэтгэл, ахиц дэвшил, үр дүнг тухай бүр хэлэлцэх, үнэлэн дүгнэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, чанарын үзүүлэлтийг сайжруулах ажлууд сургуулийн түвшинд хийгдэж хэвшиж тогтжээ.

Отгонтэнгэр их сургуулийн Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургууль нь Бизнесийн удирдлага (Санхүүгийн менежмент) хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орсноос хойш өнгөрсөн 5 жилийн хугацаанд сургуулийн хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэх, мөн сургуулиа хөгжүүлэх болон дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд явуулж буй үр дүнг үндэслэн өөрийн үйл ажиллагааг дахин үнэлж өөрийн үнэлгээний тайлангаа бэлтгэн хөтөлбөрийн 2 дахь шатны магадлан итгэмжлэлд орох бэлтгэлээ хангажээ.

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хөтөлбөр хэрэгжүүлэгч Бүртгэл менежментийн тэнхимийн сургалтын үйл ажиллагааны бүхий л түвшний хамт олныг хамруулан боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаарх журмыг удирдлага болгож БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолд заасан “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ын дагуу боловсруулж бэлтгэсэн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмаркинг, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмаркинг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад орчны хүчин зүйлсийн шинжилгээнд тулгуурлан хөтөлбөрийн хөгжлийн ирээдүйн хандлага, стратегийг боловсруулахад анхаарч ажиллаж байна.

- Элсэгч, төгсөгч, ажил олгогчдийн сонирхол, хандлага, эрэлт, сэтгэл ханамжийн судалгаа, шинжилгээний үр дүнг харьцангуй боломжийн түвшинд ашиглаж байна.
- Хөтөлбөр боловсруулахдаа санхүүгийн удирдлагын чиглэлийн сургалтаар дэлхийд болон Азид тэргүүлж байгаа их сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулсан ба дотоодын их дээд сургуулиудын санхүүгийн удирдлага хөтөлбөрүүдийн ижил төсөөтэй болон ялгаатай талууд дээр нарийвчилсан судалгааг хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчид, төгсөгчдийн сонирхол хандлагын талаар судалгаа шинжилгээ хийж, үр дүнг ашиглах

Зөвлөмж:

- Дижитал, цахим технологийн хөгжлийн эрин үеийн хэрэгцээ шаардлагад хөтөлбөрийг нийцүүлэх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн загварыг дэлгэрэнгүй, тодорхой гаргасан байна.
- Хөтөлбөрийн зорилгыг сургуулийн стратеги төлөвлөгөө, хөтөлбөр болон сургалтын төлөвлөгөөндөө тодорхойлон тусгасан төдийгүй хичээлүүдийн зорилго, суралцахуйн үр дүнтэй холбож өгсөн байна.
- Хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн өөрчлөлтийн талаар олон нийтэд сургуулийн цахим мэдээлэл, оюутны гарын авлага зэргээр дамжуулан мэдээлдэг уламжлал тогтсон байна

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулдаг журамтай болох хэрэгтэй.

Зөвлөмж:

- Оролцогч, сонирхогч талуудын саналуудыг тусгах асуудлыг цахим хэлбэрээр шийдэх боломжийг бүрдүүлэх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг суралцахуйн үр дүнтэй уялдуулан иж бүрэн боловсруулж, тогтмол сайжруулалт хийн баталгаажуулан ажилладаг байна.

Анхаарах асуудал:

- Суралцахуйн үр дүнгийн зураглалын уялдааг харуулсан логик загвар хэрэгтэй байна.

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын агуулга сүүлийн жилүүдэд тасралтгүй өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа бөгөөд энэ талаар суралцагсдын өгсөн үнэлгээ өндөр гарсан байна. /91.2%/
- Мэргэжлийн оюутнууд ба хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг, ур чадвар, хандлагад үндэслэн сургалтын төлөвлөгөөний матриц зохиож анализ хийсэн
- Оюутны үйлдвэрлэлийн дадлага танилцах ба мэргэшүүлэх гэсэн 2 түвшинтэй, дадлагын журмын шинэчлэлтийг хийсэн бөгөөд оюутнуудыг дадлага хийлгэх бааз суурь болгон Интерактив сургалтын төвийг байгуулж мөн гэрээт байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Удирдлагын мэдээллийн системийн үнэлгээг сайжруулах
- Сургалт, үйлдвэрлэлийн дадлагын удирдамжийг нарийвчлан сайжруулах
- Мэргэжлийн суурь хичээлүүдээс нэгдүгээр курст ордоггүй нь мэргэжлийн талаарх мэдлэгт сөргөөр нөлөөлөх гэсэн шүүмж гарч байгааг цаашид хөтөлбөрийн шинэчлэлт хийхэд анхаарах
- Хичээлийн онол, практикийн оновчтой харьцааг бүрдүүлэхэд гадаад, дотоодын сургуулиудын туршлагыг харьцуулан судлах
- Сургалт, үйлдвэрлэлийн дадлагын удирдамжийг сайжруулж, дадлагын үеэр баримтлах үлгэрчилсэн дүрэм боловсруулж мөрддөг байх хэрэгтэй.

Зөвлөмж:

- Суралцагсад мэргэжлийн хичээлүүдээр багшаа сонгох боломжийг бүрдүүлэхэд анхаарах
- Сургалтын төлөвлөгөөний шинэчлэл хийхэд ажил олгогсдыг оролцуулах талаар анхаарах
- Сургалтын төлөвлөгөөний шинэчлэл хийх, хичээлийн агуулгын өөрчлөлт хийхэд төгсөгчдийн саналыг тусгахад анхаарах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын арга зүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн хичээлүүдэд сургалтын идэвхтэй аргуудыг хэрэглэж байгаа бөгөөд оюутанд хэрхэн мэдлэг, ур чадвар, хандлага олгох талаар харьцуулалт судалгаа хийсэн.
- Санхүүгийн бүртгэл (DIAMOND ERP 5.0, IMPACT, PAYROLL), маркетингийн судалгаа (SPSS 22), статистик, эконометрик (EViews 9.0) зэрэг хичээлүүдэд мэргэжлийн программуудыг зохих түвшинд хэрэглэдэг.
- Багш нарын сургалтын арга зүй, заах ур чадвар дундажаас дээгүүр үнэлгээтэй байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн багш нарын мэдлэг, чадвар ялгаатай байдаг хэмээн суралцагсад үзсэн байгааг анхаарах

Зөвлөмж:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар зөвлөмжөө тодорхой дэлгэрэнгүй гаргах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны мэдлэгийг явцын болон улирлын шалгалтын нийлбэрээр 100 оноогоор дүгнэх ба нийлбэр оноог бүртгэл мэдээллийн системд оруулж, багшийн гарын үсэг бүхий дүнгийн хуудсаар баталгаажуулдаг.
- Санхүүгийн хичээлүүдээр оюутны мэдлэгийг үнэлэх үнэлгээний олон аргыг хэрэглэдэг. Үүнээс хамгийн түгээмэл нь багцаар үнэлэх арга, хаалттай шалгалтын арга, практик дасгалын аргууд байна.
- Багшийн үнэлгээний ил тод байдлыг бүртгэл мэдээллийн системээр бүрэн хангадаг.
- Дадлагын тайлангийн үнэлгээнд оролцогч байгууллагуудын хүмүүсийг тодорхой түвшинд оролцуулдаг.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хичээлүүд болон дадлагын тайлангийн үнэлгээг үнэлгээний арга зүйд тулгуурлан үнэлэх, оюутанд илүү ойлгомжтой болгоход анхаарах
- Оюутны сурлагын амжилтын түвшинд дүн шинжилгээ хийж хэвших

Зөвлөмж:

- Дадлагын ажлын тайлан хамгаалалт, бие даалтын ажлын үнэлгээг тодорхой болгож, ил тод байдлыг хангах.

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан.
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт явуулах анги танхим, лаборатори, багшийн ажиллах орчин зэрэг нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлага хангасан байна гэж үзэж байна.
- Сургуулийн харьяанд 3 компьютерийн лабораторийн хүчин чадлыг сайжруулж бусад мэргэжлийн анги танхимуудыг тохижуулсан бөгөөд эрдэм шинжилгээний төвийг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр тоногловсон байна (80 гаруй сая төгрөг).

- Сургалтын орчны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж хэвшсэн бөгөөд судалгааны үр дүн болон оюутнуудын сэтгэл ханамж өндөр байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын орчинг илүү сохирхолтой, өвөрмөц шийдэлтэй болгох;

Зөвлөмж:

- Мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжийг сайжруулах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Компьютерийн лаборатори, интерактив сургалтын төвд мэргэжлийн хичээлүүдийн сүүлийн үеийн програмуудыг (DIAMOND ERP 5.0, IMPACT, PAYROLL) албан ёсны эрхтэйгээр ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Цахим номын хүртээмж, ашиглалтыг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Дижитал сургалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа, ном ашиглалтыг сайжруулах арга хэмжээ, ном сурталчлах арга хэмжээ
- хөтөлбөртэй холбоотой сурах бичгийн жагсаалт, тэнхимийн дэргэдэх номын фонд

- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөртэй холбоотой 969 ном электрон санд фондын болон уншлагын гэсэн хэлбэрээр оюутнуудад үйлчилж байна. Мөн олон улсын онлайн эрхийг авч ашиглаж байна.
- Үндсэн сурах бичгийн баяжилтыг жил бүр тогтмол хийж, мэргэжлийн номыг сурталчлах булан ажиллуулдаг

Анхаарах асуудал:

- Багш нарын заадаг хичээлийн гарын авлагуудыг сайжруулах, нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Олон улсын эрдэм шинжилгээ судалгааны цахим сангуудыг нэмэгдүүлэх
- Мэргэжлийн чиглэлийн сурах бичиг, гарын авлагыг бичиж сургалтанд ашиглах
- Номын сан мэдээллийн эх үүсвэрийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж тайлагнадаг байх

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Отгонтэнгэр их сургуулийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт, стратеги төлөвлөгөө, /2013-2022/
- Эдийн засаг бизнесийн удирдлагын сургуулийн стратеги төлөвлөгөө, 2018-2022
- Эдийн засаг бизнесийн удирдлагын сургуулийн төлөвлөгөө, тайлан, 2015-2019
- Эдийн засаг бизнесийн удирдлагын сургуулийн стратеги төлөвлөгөө /2018-2022/-нд хийсэн шинжилгээ

- Бүртгэл менежментийн тэнхимийн төлөвлөгөө, тайлан, 2015-2019
- ОТИС-н захирлын тушаал А/164 тоот, Хөтөлбөрийн дэд хорооны хурлын протокол
- ОТИС-н Эрхзүйн баримт бичгийн эмхэтгэл, 2019
- ОТИС-н Эрхзүйн баримт бичиг шинэчлэх тухай захирлын тушаал, 2018-10-18 ны өдрийн А/147 тоот
- ОТИС-н Эрхзүйн баримт бичиг шинэчлэх ажлын хэсгийн тайлан, 2019-02-01
- Отгонтэнгэр их сургуулийн хөтөлбөрийн хорооны журам, ОТИС-ийн Эрхзүйн баримт бичгийн эмхэтгэл, 2019, 91-р хуудас
- Социологийн судалгааны тайлан, 2015-2019
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны тайлан, 2015-2019
- Захиргаа хяналт шинжилгээ үнэлгээний албаны тайлан, 2012-2019
- Удирдлагын мэдээллийн системийн OneMis програм

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх хангалттай туршлагатай, салбартаа мэргэшсэн, тогтвор суурьшилтай хүний нөөцийн баг бүрдсэн.
- Сургуулийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр эрх зүйн шинэчлэлт хийх бодлогыг тухайн хөтөлбөрт барьж ажилладаг.
- Сургуулийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлд холбогдох алба нэгж анхаарч, албан ёсны удирдамж загвар боловсруулан ажилладаг.
- Захиргаа хяналт шинжилгээ үнэлгээний алба нь сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр хөтөлбөрт харьяалагдах хэсэгт анализ хийж сургалтын үйл ажиллагаандаа тусган ажилладаг.
- Хөтөлбөрийн хорооны журам, хөтөлбөр боловсруулах журам батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.
- Бакалавр болон магистрын зэрэг олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг мэргэжлийн тэнхим болон хөтөлбөрийн дэд хорооноос гарсан санал дүгнэлтэд үндэслэн сургалтын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгадаг.

Анхаарах асуудал:

- Эрх зүйн баримт бичгийн сайжруулалт тогтмол хийгдэж байгаа хэдий ч хэрэгжилтэнд анализ хийгдээгүй
- Хөтөлбөрт ирж буй санал гомдол нь зөвхөн оюутны сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хийгдэж байгааг бусад оролцогч талуудын санал гомдлыг тусгадаг байх

Зөвлөмж:

- Хөтлбөрийн удирдлагын үйл ажиллагааг илүү ил тод нээлттэй болгох.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их, дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн тайлан, 2019
- ОТИС-н Эрхзүйн баримт бичгийн эмхэтгэл, 47-р хуудас
- Эдийн засаг бизнесийн удирдлагын сургуулийн төлөвлөгөө, тайлан, 2015-2019
- Бүртгэл менежментийн тэнхимийн төлөвлөгөө, тайлан, 2015-2019
- ОТИС-н Төгсөгчдийн холбооны дүрэм, /Эрхзүйн баримт бичгийн эмхэтгэл, 25-р хуудас/
- Сургалтын албаны дэлгэрэнгүй тайлан
- Степпелинк ХХК-тай хамтран ажиллах гэрээ
- Бид Сольюшин ХХК-тай хамтран ажиллах гэрээ
- Интерактив Би Ай ХХК-тай хамтран ажиллах гэрээ
- БСШУЯ-ны Дээд боловсрол төслийн хэрэгжүүлэгчээр хамтран ажиллах албан тоот, 2016 он
- Олон улсын мэргэжлийн хөгжлийн институттэй хамтран ажиллах санамж бичиг
- БЗД-ийн НД-ын хэлтэстэй хамтран ажиллах тухай албан тоотын хариу
- Баясах трейд ХХК-тай хамтран ажиллах гэрээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хамтын ажиллагааны гэрээг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулан ажиллаж байна.
- Мэргэжлийн холбоодуудтай хамтран ажилладаг. Үүнд: Менежментийн холбоо, Маркетингийн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Банк санхүүгийн академи, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Хүний нөөцийн менежментийн холбоо зэрэг.
- Суралцагчдыг дотоодын (Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Зориг сан, компаниудын нэрэмжит) болон гадаад улсын (Хятадын засгийн газрын 100%) тэтгэлэгт хөтөлбөрт хамруулдаг. Мөн өөрийн сургуулийн үүсгэн

байгуулагчийн, төгсөгчийн нэрэмжит тэтгэлгүүдэд суралцагчдаа хамруулдаг. Тэтгэлэг хөтөлбөрт хамрагдах тогтсон журам мөрддөг.

- Төгсөгчдийн холбоо болон төгсөлтийн дараах сургалт, эргэх холбоон дээр анхааран ажилладаг. Бакалаврын төгсөгчиддөө өөрийн сургуулийн магистрын сургалтанд хамрагдахад сургалтын төлбөрийн 10%-ийн хөнгөлөлтөнд 22 суралцагч 2016-2018 онд хамрагдан суралцсан байна.
- Тогтвортой хөгжлийн боловсрол төслийг хэрэгжүүлэн “Green Office”-ийг байгуулан “ОТИС 2030” клубын үйл ажиллагааг явуулдаг.
- БСШУСЯ-ны оюутны санаачлагыг дэмжих төслийн хүрээнд “Career center” төв байгуулан оюутны soft skills-ийг хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын гадаадын их, дээд сургууль, судалгааны байгууллагад мэргэжил дээшлүүлж, суралцах боломж хангалтгүй.

Зөвлөмж:

- Бусад их сургуулиудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн санхүүгийн албаны төсөв тайлан, мэдээ 2015-2018 он

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ЭЗБУС-ийн нийт орлогын 97% нь хөтөлбөрт буцаан зарцуулагддаг. (сүүлийн 5 жилийн дундаж)
- Сүүлийн 5 жилийн дунджаар нэг суралцагчид ноогдох зардал нь 1,968,122 төгрөг байна. ОТИС-ийн нэгдсэн санхүүгийн алба тооцон гаргадаг.
- Сургалтын төлбөрийн 73% нь багш, ажилчдын цалин, нийгмийн даатгалд, 4.8% нь оюутанд үзүүлсэн хөнгөлөлт урамшуулалд, 8.6% нь сургалт эрдэм шинжилгээ, 13.6% нь бусад зардалд хуваарилагдсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж төсөв санхүүгийн хувьд нэгдсэн байдалтай бөгөөд шууд захиран зарцуулах эрх мэдэл бүхий эрхзүйн зохицуулалтгүй.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан бие даасан төсөвгүй.

Зөвлөмж:

- Олон улсын судалгааны байгууллагын төслийн санхүүжилтаар төсөвөө бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Маркетингийн албаны төлөвлөгөө, тайлан 2016-2018 он
- Эдийн засаг бизнесийн удирдлагын сургуулийн төлөвлөгөө, тайлан 2015-2019
- Бүртгэл менежментийн тэнхимийн төлөвлөгөө, тайлан 2015-2019
- Эдийн засгийн тэнхимийн төлөвлөгөө, тайлан 2015-2019

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгааг ДХШҮА-аас төгсөгчдийг мөшгөх, төгсөгчдийн ажил эрхлэлт, элсэлтийг тандах судалгааг авч мэдээллийг маркетингийн үйл ажиллагаандаа ашигладаг.
- Элсэгчдийг татахад чиглэсэн ОТИС-ийн нэрэмжит нийслэлийн ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдын дунд сагсан бөмбөгийн тэмцээн, COSMO STUDENT OTGONTENGER UNIVERSITY цуврал сэтгүүл, Open day өдөрлөг, Мэргэжил сонголт сэдэвт лекц, Лиаонингийн их сургуулиас бэлтгэсэн нэвтрүүлэг, ОТИС-ийн нэрэмжит Instagram хэрэглэгчдийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн, 21 аймаг, 9 дүүргийн төгсөх ангийн сурагчдыг хамруулсан “Ирээдүйн эзэд” аян зохион байгуулагчаар оролцох гэх мэт ажлуудыг зохион байгуулсан.

Анхаарах асуудал:

- ОТИС-ийн маркетингийн алба нь хөтөлбөрийн сурталчилгааг хийх тал дээр анхаарах

Зөвлөмж:

- Зах зээлийн тандалт судалгааг өргөжүүлэх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

1. Сургуулийн www.otgontenger.edu.mn цахим хуудаст мэдээллийг тогтмол байршуулах

2. Удирдлагын мэдээллийн системийн MISDATA програм (ашиглаж байгаа)
3. Фейсбүүк хаяг, твиттер, мэйл хаяг, мэдээллийн самбар
 - info@otgontenger.edu.mn
 - facebook.com/OtgonTengerUni
 - twitter.com/OtgonTengerUni
 - Отгонтэнгэр их сургуулийн багш, оюутан, ажилтны нэгдсэн групп
 - bagshiin_ner@otgontenger.edu.mn
 - teachers@otgontenger.edu.mn
 - Отгонтэнгэр их сургуулийн багш ажилтнуудын групп
 - Отгонтэнгэр Хэвлэл мэдээллийн алба
 - Отгонтэнгэр Их сургууль төгсөгчдийн албан ёсны групп
4. Багшийн веб: <http://teacher.otgontenger.edu.mn>
5. Оюутны веб: <http://student.otgontenger.edu.mn>
6. Элсэлтийн бүртгэл: <http://otgontenger.gate.mn/>
7. Дипломын мэдээлэл шалгах: <http://checkdiploma.otgontenger.edu.mn/>
8. Удирдлагын мэдээллийн системийн шинэчилсэн хувилбарын танилцуулга (OneMis, 2020 оны 01 сарын 01-ээс ашиглагдаж эхэлнэ)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Удирдлагын мэдээллийн системийн сайжруулалтыг шат дараатайгаар хийж ажиллаж байна.
- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар нээлттэй ил тод байдлаар цахим хуудас тогтмол шинэчлэгддэг, мөн бусад мэдээллийн хэрэгслээр (TV, FM оюутан радио, фейсбүүк, оюутны гарын авлага, танилцуулга брошур, ЭШХ-ын эмхэтгэл материалууд, багш нарын хэвлүүлсэн ном сурах бичиг, илтгэл өгүүлэл) мэдээлдэг.

Анхаарах асуудал:

- Өнгөрсөн хичээлийн жилүүдэд ашиглаж ирсэн удирдлагын мэдээллийн системийн програм (ONEMIS) хангамжийн шинэчлэлтийг хурдасгах
- OneMis програмыг модулийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулан хяналт тавих

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн дотоод дүрэм
- ОТИС-ийн оюутан элсүүлэх журам
- ОТИС-ийн жил бүрийн элсэлтийн комисс томилох тушаал
- Элсэгчдэд зориулсан тараах материалууд
- Элсэгчдийн босго оноонд хийсэн судалгаа, дүгнэлт
- Элсэгчдээс сургуульд орох болсон шалтгааныг тодруулах судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр элсэлтийн журмыг шинэчлэн баталж, хэрэгжүүлдэг
- Тухайн жилд ажиллах элсэлтийн комиссыг байгуулж, элсэлтийн ажлыг зохион байгуулдаг.
- Элсэлтэнд ажиллах багш нараас санал авч, хөдөө орон нутагт томилолтоор ажиллуулдаг.
- Элсэгчдийн бүртгэлийг интернет болон, сургууль дээр, орон нутагт гэсэн байдлаар гэсэн 3 хэлбэрээр зохион байгуулдаг.
- Сургуулийн талаарх мэдээллийг хэвлэмэл болон web хуудас, facebook ашиглан түгээхээс гадна, телевиз, радио, үзэсгэлэн яармагт оролцох байдлаар явагддаг.

Анхаарах асуудал:

- Босго оноо харьцангуй доогуур байгаа тул цаашид өсгөх замаар элсэгчийн чанарт анхаарах

Зөвлөмж:

- Элсэгчдэд зориулсан мэдээ, мэдээллийг тодорхой, агуулга сайтай болгох

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ
- Багш нарын ангитай ажилласан тайлангууд
- Шилдэг анги хамт олон шалгаруулах журам
- Ногоон оффис төвийн үйл ажиллагаа
- Career center төвийн үйл ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн удирдлагын баг, бүтэц зохион байгуулалт тус бүрээс ажил үүргийн хуваарилалтын дагуу оюутанд зөвлөх, тэднийг хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график гаргаж үр дүнг тайлагнадаг.
- Оюутантай холбоотой дүрэм журмыг боловсруулж, мөрдөж ажилладаг.
- Сэтгэл ханамжийн судалгаа авч, түүний тайлан гаргаж, түүнтэй холбоотой ажлын төлөвлөгөө гаргаж ажилладаг.
- Олимпиад АСТ, уралдаан, тэмцээнд оюутнуудыг удирдаж оролцуулдаг.
- ЭЗБУС дээр 10 дугуйлан ажиллаж, оюутнуудад нээлттэй хичээллэдэг.
- Оюутныг хөдөлмөр эрхлэлт, цагийн ажилд зуучлах зорилготой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулагдан ажилладаг.
- Эрдэм шинжилгээ судалгааны төвтэй бөгөөд жил бүр төлөвлөгөө гаргаж, түүний дагуу ажиллаж тайлан гаргадаг.
- Шинээр докторын зэрэг хамгаалсан багш нар жил бүр эрдэмтний индэрт уригдаж, туршлагаа шинэ залуу багш, магистрант, докторантуудад танилцуулдаг.

Анхаарах асуудал:

- Зөвлөн туслах үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, тэдгээртэй холбоотой тайлан гаргаж, дүн шинжилгээ тогтмол хийдэг болох

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Олимпиадад оролцсон тухай тайлан, бэлтгэл ажлын төлөвлөгөө
- Олимпиад болон уралдаан тэмцээнд гаргасан амжилтууд
- АСТ, уралдаан тэмцээн зохион байгуулах, төлөвлөгөө, тайлан
- Хэрэгжүүлсэн МОНО төслүүд, тайлан
- Оюутны холбооны ажлын төлөвлөгөө, тайлангууд
- Оюутнуудын хэрэгжүүлсэн МОНО төслүүд
- Анги сурталчлах ажлын тайлангууд
- Мэргэжил сурталчлах ажлын тайлангууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОТИС-ийн үүсгэн байгуулагчийн нэрэмжит тэтгэлэг, төгсөгчийн нэрэмжит тэтгэлэг олгодог.
- Үндэсний болон урамшуулалт тэтгэлэгт хамруулах

- Төрийн болон төрийн бус байгууллага, сан, банк санхүүгийн байгууллагаас зарласан тэтгэлэгт оролцоход нь дэмжлэг үзүүлэх
- Улсын болон бусад байгууллагаас олгодог тэтгэлэгт оюутнуудаа тодорхойлж, аль болох олон оюутнуудыг хамруулахыг зорьдог.
- Тогтвортой хөгжлийг дэмжих 2030 клуб ажиллагааг.
- Моно төслүүдийг санаачлан хэрэгжүүлдэг.
- Шилдэг судлаач, шилдэг удирдагч, шилдэг анги хамт олон жил бүр шалгаруулж, алдаршуулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудыг олон нийтийн ажилд аль болох жигд оролцуулах, тэтгэлэгт хөтөлбөрийн тоо, чанарыг дээшлүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн дүрэм
- ОТИС-ийн бакалаврын сургалтын журам
- ОТИС-д оюутан шилжүүлэн суралцуулах журам
- Дахин шалгалт өгөх, хичээлийг дахин судлах, нэмэлт багц цаг цуглуулах журам
- Оюутны оюутны шилжилт хөдөлгөөнийг дээрх дүрэм, журмын хүрээнд зохицуулагддаг бөгөөд оюутны чөлөөнөөс ирж үргэлжлүүлэн суралцаж байгаа тухай сургуулийн Захирлын тушаал гардаг. Үүнд:

Суралцагч оюутныг сургуулиас чөлөөлөх, хасах асуудлыг ОТИС-ийн бакалаврын сургалтын журамд заасныг үндэслэн шийдвэрлэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, кредит дүйцүүлэн тооцох журмыг баримтлан ажилладаг.
- Оюутнуудын шилжих санал хүсэл, өргөдлийг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэдэг.
- Жил бүрийн эцэст шилжилт хөдөлгөөний тайлан гаргаж, шилжих болсон шалтгааныг тодруулж авч хэлэлцдэг
- Шилжин ирсэн оюутны судалсан кредитыг хүлээн зөвшөөрч, судлаагүй хичээлийг нөхөн судлах боломжийг олгодог.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын шилжилт хөдөлгөөний тайланг зөвхөн нэг жилээр гаргаж хэлэлцэх бус олон жилийн динамик гаргаж, харьцуулалт хийх замаар дүн шинжилдэг байх
- Оюутнуудын шилжих болсон шалтгааныг илүү сайн тодруулж, тогтвортой суралцах боломжийг олгох
- Оюутнуудад хандсан тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн шалгалтын төв болон салбар комисс томилох захирлын тушаал
- Төгсөгчийн ажил эрхлэлтийн тушаал
- Төгсөгчдийн мөшгөх судалгаа
- Төгсөлтийн дипломын ажилд тавигдах шаардлага, стандарт
- Төгсөгчдийн товч анкет
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа, төлөвлөгөө тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр төгсөлтийн шалгалтын комиссыг байгуулж, шалгалт өгөх эсвэл диплом бичиж хамгаалах боломжийг сонгох боломжтой.
- Төгсөлтийн дипломын ажилд тавигдах шаардлага, стандартыг гаргаж мөрддөг.
- Төгсөлтийн шалтгалтыг бичгээр болон амаар гэсэн 2 хэлбэрээр авах бөгөөд шалгалтын материалыг жил бүр шинэчлэн боловсруулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудыг аль болох дипломын ажил хамгаалуулах боломжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-н Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр
- ОТИС-н Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2019
- Сургалтын байгууллагын 3 дахь шатны магадлан итгэмжлэл шалгуур-4 хуудас 80
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сургуулийн доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин /ЭЗБУС-ийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан 2014-2019/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /ЭЗБУС-ийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан 2014-2019/
- Багш нарын кредит цагийн тооцооны нэгтгэл тайлан- ЭЗБУС 2014-2019
- Сургалтын нэгдсэн албаны нэгтгэл тайлан 2014-2019
- Сургалтын байгууллагын 3 дахь шатны магадлан итгэмжлэл шалгуур-8 хуудас 125

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОТИС-ийн хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулийн хувьд хүний нөөцийн бодлого зохицуулалт тогтворжиж, багш ажилчдын хувьд тогтвор суурьшилтай ажиллах таатай нөхцөл бүрдсэн байна.
- Сүүлийн жилүүдэд доктор багш нарын эзлэх хувь тогтмол өсөж байгаа нь багш нарын эрдэм судлалын ажлыг дэмжих тогтолцоо бүрдсэн байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын хувьд албан тушаалын зэрэглэл өсөх боломж нээлттэй ил тод байх тогтолцоо бүрдэж чадсан байна.
- Хичээлийн цагийн ачаалал нь хэвийн, эрдэм судлалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн байна.
- Багшлах боловсон хүчнийг чадваржуулах, эрдмийн зэрэг цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх урамшууллын хөшүүрэг бодитоор бий болгосон.

Анхаарах асуудал:

- Багшийн нийгмийн үйлчилгээ, олон нийтэд чиглэсэн, сайн дурын ажлыг үнэлэх тогтолцоог сайжруулах
- Багшийн цалин хөлсийг инфляцийн түвшинтэй уялдуулан өсгөж байх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-н Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр 2018
- Багш хөгжлийн төвийн тайлан 2018-2019

- ЭЗБУС-ийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан 2014-2019

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт хийх тогтолцоог бүрдүүлсэн дүрэм, журам мөрдөгдөж зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлдэг ажил хэвшиж тогтсон.
- Багшлахуйн ур чадвар, сургалт судалгааны ажлыг сайжруулах ажлын хүрээнд “Эрдэм шинжилгээ судалгааны төв”, “Багш хөгжлийн төв”-ийг байгуулан, багшийн хэрэгцээ шаардлагыг судлан сургалт семинар тогтмол зохион байгуулж байна.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж түүний үр дүнг тайлагнах үйл явц тогтмолжсон байна.
- Багш нарын хөгжлийг дэмжих ажлын хүрээнд гадаад, дотоодын сургалт, семинарт багш нарыг хамруулах, санхүүгийн нөөц боломжоор дэмжих тогтолцоо бүрдсэн байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлд хэвлүүлсэн судалгаа өгүүлэл бага.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-н Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2019
 - ✓ ОТИС-н сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага 2018
 - ✓ ОТИС-н эрдэм шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх хөтөлбөр
- Багш нарын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт оролцсон байдал
 - ✓ (ЭЗБУС-ийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан 2014-2019)
- ОТИС-ийн эрдэм шинжилгээний төвийн нэгтгэл тайлан 2014-2019
 - ✓ Сургалтын байгууллагын 3 дахь шатны магадлан итгэмжлэл шалгуур-8
 - ✓ ЭЗБУС-ийн багш нарын гарын авлагын жагсаалт
 - ✓ ЭЗБУС-ийн багш нарын илтгэл
 - ✓ ЭЗБУС-ийн багш нарын өгүүлэл
- ЭЗБУС-ийн оролого зарлагын нэгдсэн тооцоо /Санхүүгийн алба/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Доктор, профессор багш нар судалгаа шинжилгээний ажлын үр дүнг оюуны өмчөөр баталгаажуулж патентжуулж байна.
- Доктор, профессор багшийн зэрэглэлд тавигдах шаардлага, судлаач багшийн шалгуурт заасанчлан багш өөрийн судалгаа шинжилгээний ажлын үр дүнг олон улсын “IF” өндөр сэтгүүлд хэвлүүлж нийтлүүлэх шаардлагатай байдаг. Энэхүү шалгуурт нийцүүлэн эрдмийн зэрэг цолтой багш нарын хувьд өөрийн эрдэм судлалын ажлын үр дүнг олон улсын хэвлэлд нийтлүүлэх ажил эрчимжиж эхэлсэн байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд шаардлагатай дүрэм журам, зохион байгуулалтын ажил тогтмолжиж материаллаг орчин нөхцөлийг хангасан, дэмжлэг урамшууллын тогтолцоо бүрдсэн байна. Тухайлбал: Докторант багшийн сургалтын төлбөр ийн 50-100%-ийн хөнгөлөлт, докторын зэрэг хамгаалсан багшийн 3,000,000 сая төгрөгний урамшуулал
- Багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажилтай холбогдох бүхийл эрх зүйн бодлого зохицуулалт 2019 онд журамлагдан батлагдсан байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулийн хувьд хэрэгжсэн төслийн ажлын үр дүнг сургалтын хөтөлбөрт тусган бодитой ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. “Career development center”, “Green office” зэрэг төвүүдээр дамжуулан оюутнуудаа хөгжүүлж байна.
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, ишлэгдсэн тооны хувьд ОТИС-ийн нэгдсэн тайланд жил бүр тусгагдан тайлагнагддаг байна.
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын хүрээнд зарцуулсан төсөв тайлан жилийн эцсийн нэгдсэн дүнгээр тогтмол гардаг.

Анхаарах асуудал:

- Гадаад, дотоодын мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, багш нарын практик чадвар, хэлний мэдлэгийг сайжруулан, төсөл хөтөлбөрт хамрагдах нөөц бололцоог нэмэгдүүлэх, төслөөс орох мөнгөн урсгалыг нэмэгдүүлж багш нарын цалин урамшуулалын санхүүжилтийг өсгөх, төсөл хөтөлбөртэй холбоотой багш нарын судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, салбартаа хүлээн зөвшөөрөгдөх нөөц бололцоог бий болгох

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-н Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2019
- ЭЗБУС-ийн багш нарын аттестатчлалын тайлан
- ОТИС-н Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2019
✓ (ОТИС-ийн дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх журам)

- ✓ Сургалтын байгууллагын 3 дахь шатны магадлан итгэмжлэл шалгуур-2/2/
- ✓ Багш нарын талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа /2014-2019/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн өөрийн үнэлгээний тайлан боловсруулахад шаардлагатай дагаж мөрдөх эрх зүйн бодлого зохицуулалт батлагдан мөрдөгддөг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулийн багш нарын жил бүрийн өөрийн үнэлгээний нэгтгэл тайлантай
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулийн оролцогч талуудын үнэлгээг тогтмол авч сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлдэг. Тухайлбал: ISO 9001 чанарын баталгаажуулалт хийж үйл ажиллагааны зураглал баталсан, чанарын нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн.
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ тогтмолжиж жил, улирал бүрээр “Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний албанд нэгтгэгдэн боловсруулагдаж”, үр дүнд үндэслэгдэн төлөвлөгөөт ажлууд байнга хийгддэг байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын хувийн хавтасны бүрдүүлэлт бүрэн гүйцэд бүрдсэн

Анхаарах асуудал:

- Багшийн ажлын үнэлгээ бага, цалин урамшуулалын тогтолцоо өрсөлдөгч байгууллагуудтай харьцуулахад сул

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарыг сайжруулахын тулд Төлөвлөх-Хэрэгжүүлэх-Шалгах-Сайжруулах (PDCA) гэсэн циклийн дагуу үйл ажиллагаа явуулж БСШУЯ-ны сайдын А/174 тоот тушаалын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу 2016, 2018 онуудад хөтөлбөрийг сайжруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлуудын тайлан болон нотлох баримтууд хангалтгүй байна.

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааг иж бүрэн хийдэг байх
- Судалгаагаар гарсан үр дүнгүүдийг хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлдэг, дүгнэлт хийдэг байх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгч, ажил олгогч, карьерийн өсөлтийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол явуулдаг бөгөөд ажил олгогчдоор үйлдвэрлэлийн дадлага удирдуулах, сайн ажиллаж байгаа төгсөгчдөө сурталчлан тэдэнтэй холбоотой ажиллан шинэ төгсөгчдийг ажилд зуучилдаг. Зөв хандлагатай оюутан бэлтгэхэд ихээхэн анхаардаг.

Анхаарах асуудал:

- Оюутнууд мэргэжлийн програмыг нийтээрээ эзэмшсэн байдал, хэлний түвшин дундаас доогуур байгаа гэсэн оюутны шүүмжийг хүлээн авч сайжруулж ажиллахад анхаарах
- Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгааг хийдэг байх

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрны шаардлагыг хангахын тулд суралцагчдын хэлний мэдлэгийг ахиулах
- Мэргэжлийн хичээлүүдийг E–хичээл болгон хувиргах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ✓ Хөтөлбөрийн тогтвортой байдлыг ханган ажиллах, үндэсний болон олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэлд орж суралцагчдын чадамжийг нэмэгдүүлэх, олон улсын түвшинд суралцах боломж бүрдүүлэхээр ажиллаж байна.
- ✓ ACBSP – Бизнесийн сургууль, хөтөлбөрийн олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн.

Анхаарах асуудал:

- ✓ Мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байдал дутмаг

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид, багш ажилтнуудтай хийсэн уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Отгонтэнгэр их сургуулийн Эдийн засаг бизнесийн удирдлагын сургуулийн “Бизнесийн удирдлага” (Санхүүгийн удирдлага) хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг



Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

IV. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

✓

V. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

✓